



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 832

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.1.3, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон нийт 220,320,195.00 (хоёр зуун хорин сая гурван зуун хорин мянга нэг зуун ерэн таван) төгрөгийн үнэ бүхий барилгуудыг хавсралтад заасан байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд болон түүний Улаанбаатар хотын Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга А.Золзаяа, Хөгнө Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга Б.Эрдэнэчимэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгөөр бий болсон хавсралтад заасан хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтаар хүлээн авах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

000658

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2020 оны 1 дугаар сарын 28 ны өдрийн
 538 дугаар тогтоолын хавсралт

**УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БИЙ БОЛСОН ТӨРИЙН ӨМЧИД
 БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/Д	Төсөл, арга хэмжээний нэр хүчин чадал, байршил	Нийт өртөг /төгрөгөөр/	Ашиглалтад орсон он, сар, өдөр, актын дугаар	Бүртгэж авах хуулийн этгээдийн нэр
1	Цаг уурын шинжилгээний барилга	89,634,000.00	2020.01.28 2020/67	Улаанбаатар хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төв
2	Оффисийн барилга	130,686,195.00	2019.11.04 2019/35	Хөгнө Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа
	Нийт дүн	220,320,195.00		
	(хоёр зуун хорин сая гурван зуун хорин мянга нэг зуун ерэн тав)			